

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 05 дугаар сарын 19-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-9

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 10-34

1.Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	11-15
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/	15-17
3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/	18-19
4.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	21-24
5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	25-27
6.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	27-29
7.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	29-33

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
05 дугаар сарын 19-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 22 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга, Д.Үүрийнтуяа, Б.Чойжилсүрэн;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Т.Аубакир, Ж.Батсуурь, Ж.Баясгалан, Х.Болормаа, Ж.Ганбаатар, Ч.Номин, Д.Пүрэвдаваа;

Эмнэлгийн чөлөөтэй: П.Сайнзориг.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар хэлэлцэх асуудлын дарааллын 9 дүгээрт орсон Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 5 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг хэлэлцэх асуудлын дарааллын 8 дугаарт орсон Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн 2026.03.30-ны өдөр өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын

дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Д.Жаргалсайхан, Д.Энхтүвшин нарын тавьсан асуултад Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр Сангийн сайд З.Мэндсайханыг хуралдаанд ирэх хүртэл уг асуудлыг түр хойшлуулж, “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16

62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, уг асуудлыг түр хойшлуулав./16:02/

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Да.Цогтбаатар нар үг хэлэв.

Н.Наранбаатар: “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын тавьсан асуултад Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам хариулж, тайлбар хийв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Төслийн 3 дахь заалтын “Төсвийн байнгын хороо” гэснийг “Төсвийн зарлагын хяналтын дэд хороо” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 11
Бүгд: 16
31.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Н.Наранбаатар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	6
Бүгд:	16

62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн дэд сайд Б.Хулан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын мэргэжилтэн Н.Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга Д.Сайханчулуун, Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга Б.Буяннэмэх, Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд, Гаалийн ерөнхий газрын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Энхтайван нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн тавьсан асуултад Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар уг хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу түр хойшлуулав./16:38/

Тав.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн дэд сайд Б.Хулан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын мэргэжилтэн Н.Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогнараран, мөн газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга Д.Сайханчулуун, Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга Б.Буяннэмэх, Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд, Гаалийн ерөнхий газрын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Энхтайван нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн тавьсан асуултад Сангийн дэд сайд Б.Хулан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын мэргэжилтэн Н.Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар уг хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу түр хойшлуулав./16:46/

Зургаа.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн дэд сайд Б.Хулан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын мэргэжилтэн Н.Эрдэнэ, Төсвийн орлогын

хэлтсийн дарга Л.Ичинноров, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга Д.Сайханчулуун, Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга Б.Буяннэмэх, Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд, Гаалийн ерөнхий газрын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Энхтайван нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар уг хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу түр хойшлуулав./16:52/

Долоо.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн дэд сайд Б.Хулан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын мэргэжилтэн Н.Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга Д.Сайханчулуун, Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга Б.Буяннэмэх, Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд, Гаалийн ерөнхий газрын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Энхтайван нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Да.Цогтбаатар нарын тавьсан асуултад Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар уг хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу түр хойшлуулав./17:06/

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Н.Наранбаатар: Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Н.Наранбаатар: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Н.Наранбаатар: Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Н.Наранбаатар: 1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн

2.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 49 минут үргэлжилж, ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр 17 цаг 11 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 19-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 22 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 53,3 хувьтай бүрдсэн тул Төсвийн байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр нь танилцуулна. Далайн Батбаяр, Хүрэлбаатарын Булгантуяа, Хассуурийн Ганхуяг, Батжаргалын Заяабал, Ганзоригийн Тэмүүлэн, Дашцэрэнгийн Энхтүвшин, Ренчиндоржийн Батболд, Гомбын Ганбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Банзрагчийн Түвшин, Жигжидийн Батжаргал, Пүрэвжавын Ганзориг, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Нанзадын Наранбаатар, Даваагийн Цогтбаатар.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал Гадаадын зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл, Засгийн газар /ЗГ/ 2026 оны 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг. Байнгын хорооны тогтоолын төсөл Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай. Байнгын хорооны тогтоолын төсөл Ажлын хэсэг байгуулах тухай. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын ЗГ-аас 2026 оны 5 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /ААНОАТ/-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын ЗГ-аас 2026 оны 5 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. Хувь хүний орлогын албан татвар /ХХОАТ/-ын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Монгол Улсын ЗГ-аас 2026 оны 5 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. Нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Монгол Улсын ЗГ-аас 2026 оны 5 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. 8.ХХОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын 32 гишүүн 2026 оны 3 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. 9.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн төсөл, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж нарын 5 гишүүн 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх үргэлжилнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Өнөөдрийн Төсвийн байнгын хорооны хурал дээр хэлэлцэх асуудлаар НӨАТ-тай холбоотой хууль дээр хууль санаачлагч нь эрүүл мэндийн

шалтгаанаас эмнэлэгт үзүүлээд явж байгаа учраас энэ асуудлуудыг хойшлуулах санал гаргаж байна.

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүний гаргасан горимын саналаар. Гишүүд орж ирээрэй, санал хураалт явах гэж байна.

Ганбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлтгээрэй. Батболд гишүүн юунд бэлдсэн үү, санал хураалтад бэлдээрэй. 11. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 62,5 хувиар дэмжигдлээ. Нэмэгдсэн өртгийн албан татварын өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Пүрэвдорж нарын 5 гишүүн санаачилсан хойшлууллаа. Ганхуяг гишүүн горимын санал гаргая.

Х.Ганхуяг: Баярмаа гишүүн болон бусад гишүүдийн өргөн барьсан ХХОАТ-ын хуулийн төслийг дараа долоо хоногийн байнгын хорооны хурлаар хэлэлцэх санал гаргаж байна.

Н.Наранбаатар: Баярмаа нарын санаачилсан ХХОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хойшлуулъя гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 68,8 хувиар дэмжигдлээ. Энэ асуудал хойшлогдлоо. Ингээд 2 асуудал хойшлогдлоо. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Нэг дэх асуудал Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Огнонгийн Хуягцогт Эрчим хүчний яам /ЭХЯ/-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Уранбаатарын Чинзориг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани /ТӨХХК/-ийн Гэрээ, эрх зүйн газрын дарга.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл 5 зүйлтэй. Төслийг зүйл тус бүрээр хэлэлцэж эхэлье. Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой, холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Алга байна. Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хууль санаачлагчаас л асууя даа. Ер нь яах вэ энэ хуулийн төслийг дэмжихгүй байгаа. Төслүүд нь явахыг дэмжиж байгаа. Гэхдээ газрын тос боловсруулах үйлдвэр Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц /УЦС/ зэрэг төслүүдийг Занданшатар Ерөнхий сайдын үед ч тэр, Учрал Ерөнхий сайдын үед ч тэр чуулган 3 сарын 15-нд эхэлсэн энэхүү төслүүд явах эсэх нь тодорхой гэж үзэж байгаа бол 3 сарын 15-наас хойш Хөгжлийн банктай холбоотой хуулийн шаардлагатай өөрчлөлтүүдээ хийвэл хийгээд, Эрдэнэбүрэний УЦС-ыг санхүүжүүлж байгаа Хятадын талтайгаа холбоо бариад, газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийн санхүүжүүлэгч буюу Энэтхэгийн талтайгаа холбоо бариад, бид энийг Хөгжлийн банкин дээрээ дамжуулаад хэрэгжүүлээд явмаар байна гэдэг асуудлуудаа Хөгжлийн банкаараа явуулаад ороод ирсэн бол.

Энэ чинь жишээлэхэд Төсвийн хуулиас гаргах гэж байгаа нь Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС барих төсөл гээд энэ 2 төслийг төсвийн гадуур бодож явна шүү гэдэг энэ тооцоолол руу Монгол Улс төсвийнхөө хуулиас гадуур орох гэж байгаа юм. Тэгээд энийг жишээлэхэд олон улсын байгууллагууд харахдаа юу гэж харах вэ гэхээр Монгол Улс өөртөө зориулж хууль батлаад байна л гэж харна уу гэхээс яг энэ аргачлал тооцооллынхоо хувьд төсвөөсөө гаргачихсан юм байна, энийг энэ олон улсын байгууллагууд зээлдэгч байгууллагуудад зөвөөр ойлголт өгөх ямар ч боломжгүй хуулийн төслийг одоо бид хэлэлцээд сууж байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ дээр яаж зөв гарцыг нь томъёолох ёстой юм гэдэг юм уу, нэг тийм гарцынх нь хувилбарыг л асуух гэсэн юм. Би Сангийн яамнаас гэх юм уу, уг нь энэ сайд нь байж байвал зүгээр байх юм. Сайдаас нь асуулт асууя. Сайдыг нь орж ирэхээр асуултаа асууя.

Н.Наранбаатар: Сайд нь тэр Оюу толгой /ОТ/-н ажлын хэсгийн уулзалтад сууж байгаа юм байна. Хэн хариулах юм бэ? 8 номер. Тэгвэл сайдаа дуудаарай. Надад бол ОТ ажлын хэсгийн хуралд сууж байна гэсэн. Сайд яачхав, дуудаач, холбоо бариач. Жаргалсайхан гишүүн асуултаа асуучихъя.

Д.Жаргалсайхан: Ингээд бид хэд 2 төслийг явуулах нь зүйтэй гээд дэмжиж байгаа. Би энийг дэмжиж байгаа. Энэ дээр нэг асуудал байгаа. Хэдүүлээ ер нь энэ төслөө ажлын хэсэг гаргаад, нэг очиж үзээд, яг ямар явцтай явж байгаа, тэгээд яг одоо ингээд энэ хууль батлагдаад, дэмжигдээд явахаар ямар үр дүн гарах юм гэдэг юмаа л их тодорхой болгохгүй бол авч байгаа мэдээлэл газрын тосон дээр очсон ажлын хэсэг ажил маш хангалтгүй, хийгдсэн ажлууд нь эхнээсээ ингээд тоногдоод, эзэнгүйдээд иймэрхүү байдалтай байна гэдэг асуудал яригдаад байгаа юм. Тэгэхээр энэ, энэ зүйл дээр ер нь бид цаашдаа энэ чинь төсөв, ТЭЗҮ нь хэдэн жилээр гарсан юм бэ? Тэгэхээр энэ хууль батлагдсанаар ажил маш их шуурхайлах гэж байна шүү дээ. Тэгэхээр энийг цаашдаа ашиглах тал дээр нь ер нь түргэвчлэх, хурдан шуурхай явах тал дээр нь ямар өөрчлөлтүүд орох юм бэ, ямар үр дүн гарч байгаа юм бэ энэ хууль батлагдсанаараа гэдэг дээр хариулт авмаар байна? Тэр тусмаа газрын тос дээр.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? 9 номер.

Ж.Дэлгэржаргал: Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Газрын тос боловсруулах үйлдвэрийн хувьд одоо яг ажлын гүйцэтгэл 40 гаруй хувьтай явж байгаа. Нийт яг хэлэлцээрийн дүн 6,1 их наяд. Одоо яг энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн хувьд УИХ-аас яг баталсан хэлэлцээрийн хугацаа 2028 онд дуусах хугацаатай. Өөрөөр хэлбэл бид энэ хугацаанд багтаад,

гүйцэтгэл гараад, үйлдвэр ашиглалтад орох, мөн яг ЗГ-ын авч байгаа энэ 6,1 их наядыг бид ашиглаад, зээлийн ашиглалтаа гаргасан байх шаардлагатай. Тэгэхээр энэ хуулийн хувьд яг одоогийн явж байгаа Төсвийн хууль, Төсвийн тогтвортой байдлын, мөн төсвийн дүрмүүдээс нэг л өөрчлөлтийг бид энэ хуулиар эрхийг нь авч байгаа. Тэр нь болохлоор яг тухайн жилийн төсвийн нийт зардал дээр гадаад зээлийн ашиглалт яг төсвийн урсгал зардал шиг тооцоололд оруулахаас зөвхөн энэ 2 төслийн гүйцэтгэлээрээ гарах ашиглалтын хэмжээг энэ хуулиар тусад нь зохицуулж явах асуудал байгаа юм. Бусад өрийн болон нягтлан бодох бүртгэл, тайлагналт одоогийн хуулийн зохицуулалтуудаараа яг хэвээрээ.

Хуулийн төслийн ил тод байдал, хяналт гэдэг дээр тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан өргөн барих, дараа жилийн төсвийн төсөл өргөн барихдаа энэ хуулийн хүрээнд гүйцэтгэл хэр гарсан, санхүүжилтүүд яаж явж байгаа талаар ил тод тайлагнахаар хуулийн төсөлд оруулсан байгаа. Нөгөө талдаа гадаад зээлийн төслүүдийн хувьд дотоодын төсвийн хөрөнгө оруулалтаас нэг ялгаатай асуудал нь хяналтын асуудал байдаг. Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн хувьд Монголын газрын тос боловсруулах үйлдвэр төрийн өмчит компани яг энэ төслийг хэрэгжүүлж, тусгайлан явж байгаа. Эрдэнэбүрэнгийн УЦС дээр мөн хэлэлцээр дээрээ байгаа төсөл хэрэгжүүлэх нэгж явж байгаа. 2 талаасаа хөгжлийн түнш зээл олгогч тал болон Монголын ЗГ 2 талаасаа байнгын хяналтуудыг хэрэгжүүлээд тайлангаа ингээд гаргаад явдаг.

Н.Наранбаатар: Жаргалсайхан гишүүн тодруулъя.

Д.Жаргалсайхан: Энэ эзэнгүйдсэнтэй холбоотой ямар тайлбар хэлэхээр байна, тэгээд энэ төслөөс хүмүүс байна уу, энэ дээр хариулт өгөөч?

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн 2 дахь микрофон хариулт, нэр, албан тушаалаа хэлээд.

У.Чинзориг: Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК-ийн Гэрээ, эрх зүйн газрын дарга Чинзориг. Гишүүний асуултад хариулъя. Төсөл нийт 4 ЕРС гэрээний хүрээнд хэрэгжиж байгаа. 1 дүгээр ЕРС гэрээ бол 2021 оноос эхлээд барилга угсралтын ажил нь дуусаад, 24 онд ашиглалтад оруулаад, байнгын ашиглалтад оруулаад эхний энгийн иргэний барилга байгууламжуудыг бүгдийг нь ашиглаад явж байгаа. Тэрэн дээр эзэнгүйдээд яасан юм байхгүй. Бүгдийг нь төсөл хэрэгжүүлэгч нэгжээс бүгдийг нь ашиглалт арчилгааг нь бүгдийг нь хариуцаад явж байгаа.

Н.Наранбаатар: Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: 2018 онд эхэлсэн Газрын тос боловсруулах үйлдвэр 2016 оноос завсаргүй хяналтгүй засаг барьсан Монгол Ардын нам /МАН/-ын байгаа царайг харуулж байгаа юм. Өнөөдөр 126 гишүүнтэй болсон 68 нь нэг намынх. МАН дотроо хэрэлдээд, асуудлаа шийдэж чадахгүй явсаар байгаад одоо асуудал нь хүндрээд яаралтай горимоор орж ирж байгаа юм. 16 оноос хойш энэ засгийг барьж байгаа нам 18 онд эхэлсэн төслүүдийнхээ ядахдаа 5, 10 жилийн цаадах наадхыг харж чадахгүйгээр одоо ингээд бүүр талцал хуваагдал нь эцэстээ хүрээд явж байгаагийн ийм бодит илэрхийлэл энэ. МАН буюу улаан намын цагаан байрныхан хулгай хийхдээ л гаршсан. Ариунзаяа гишүүн үнэнээ хэлсэн шүү дээ. Бид Төсвийн тухай хууль дээрээ 2 нүдээ дарчихаар би нуугдчихлаа гэж байгаа юм шиг болоод

байна. Зарчим нь энэ чинь нуугдаж чадаагүй байгаа төсвийн тооцоолол. Тэгээд энэ дээр нь Төсвийн байнгын хорооны дарга ч гэсэн хатуу байр суурьтай баймаар байна. Улсын Их Хурлын дарга, УИХ ч гэсэн хатуу байр суурьтай баймаар байна.

Тэгээд энэ газрын тос боловсруулах үйлдвэрийг бид амин чухал хэрэгцээтэй, Төсвийн тухай хуульд хамаагүй гэж ЗГ тайлбарлаж байгаад хэлэлцээд явъя гэхээр Сангийн сайд чинь алга байна, Газрын тос боловсруулах үйлдвэрийн чинь дарга алга байна. Энэ УИХ, энэ Байнгын хороод ер нь зүгээр нэг ийм хонгио барьж байгаад бид хашхираад, тэр нь эзэнгүйдэж байгаа юм шиг л ажил явдаг болоод байна. Энийг анхааруулж хэлээд байгаа юм. Тэгээд сая энэ төсвийн гүйцэтгэл төсөл чинь өөрөө тэнчээ хамаг юм нь тоногдоод байгаа юм биш үү? Тэр хүртэл энийг үзэж харж байгаад явъя гэхээр юм нь явж байгаа гэж худлаа тайлбар өгч байгаад л явах гээд байна шүү дээ. Бодит байдлыг нь очиж үзье л дээ, харъя л даа. Юуг нь нуугаад байгаа юм. Тэгээд хамаг юмаа ил тод ярья гэхээр бүгдийг нь ингээд булзааруулаад далд хийгээд л, дараагийнхаа хулгайд бэлдээд байдаг юм уу? Төсвийн байнгын хороо Улсын Их Хурлын нэрийн өмнөөс Улсын Их Хурлын талдаа ажилламаар байна. Битгий Сангийн яам эсвэл Газрын тосны боловсруулах үйлдвэрийн хулгайн талд ажиллаад бай. Улсын Их Хурлын дарга ч гэсэн энэ үгийг дайчихмаар байна.

Н.Наранбаатар: Одоо ирж байна гэж байна, ирэхээр нь. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Энэ 3 дугаар бүлэг буюу Хяналт, ил тод байдал гэсэн бүлэг байгаа. Тэрний 4 дүгээр зүйл дээр энэ ил тод байдал, хяналт дээр яах вэ ерөнхий тусгачихсан байгаа юм. Энийг зүгээр дэлгэрүүлээд тодорхой хугацаа тавивал тийм бололцоо боломж байгаа юу? Энэ юугаар болохоор 4.1 дээр хэрэгжилтийн талаарх тайланг тухайн жилийн Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн хамт УИХ-д хүргүүлнэ гэж байгаа юм. Энэ дээр яах вэ тодорхой хугацаа тавивал тийм санал байгаа юу? Тэдний дотор ч гэдэг юм уу ийм хугацаанд хүргүүлнэ гэсэн.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? 9 номер.

Ж.Дэлгэржаргал: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дээр болохоор нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт гээд тэгж байгаа. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан өөрөө Төсвийн тухай хуульд зааснаар өөрөө цаглавартай. Одоо яг тухайн тухайн жилдээ өмнөх жилийн гүйцэтгэлийн тайлан 6 сарын 10-нд УИХ-д өргөн барьдаг. Тэрний өмнө болохоор аудитад 5 сарын 10-нд ингээд сар, сар болгондоо ЗГ төсвийн шууд захирагч, төвлөрүүлэн, ерөнхийлөн захирагчид, дээрээс нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний аудитын газарт хэзээ тайлан хүргүүлэх вэ гэдэг нь яг 6 сарын 10 хүртэл Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаатай байдаг. Яг энэ гүйцэтгэлийнхээ тайландаа яг энэ хугацаандаа оруулахаар ингэж төлөвлөж хуулийн төсөлд тусгасан.

Н.Наранбаатар: Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга. Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга. Монгол Улсын Их Хурлын чуулганы, горимын санал Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Энэ хууль нэг удаагийн үйлчлэлтэй хууль. Тэгэхдээ бид энэ 2 төслийг төсвийнхөө харилцаанаас гаргачихсан юм биш. Бүртгэл, хяналт, тайлагнал эд нарыг гаргаагүй. Энэ 2 төслийн гүйцэтгэлийн дүнгээр төсвийн өнөө тусгай шаардлагуудын хэтрэлт гарч болно, тэр нь юунд хамаарахгүй шүү л гэж хэлсэн. Тийм учраас энд бид төсвөөс гаргачихсан, хяналтгүй болгочихсон, 2 төсөвтэй болгочихсон энэ тэр юм байхгүй. Үүнийг хэдүүлээ 1 дүгээрт зөв ойлгох ёстой шүү гэдгийг зориуд хэлмээр байна. Энэ Монгол Улсад төсөв яаж төлөвлөгдөж, зохиогдож, батлагдаж, яаж хэрэгжиж, яаж тайлагнагдаж, яаж хяналт тавьдаг вэ яг тэр зарчмуудаараа энэ 2 төсөл явна шүү гэдгийг зориуд хэлмээр байна.

Нэгэнт энэ 2 төсөл дээр бид энэ хаваржин ярьцгаасан. Бүгд ойлгогдсон. Энэ үндэсний эрх ашиг, аюулгүй байдал бүх юмтайгаа холбоотой юм гэдэг бүх юман дээр гишүүд нэгдсэн ойлголтод хүрсэн. Тийм учраас би зарчмын зөрүүтэй санал энэ анхны хэлэлцүүлгээр гарахгүй байгаа учраас энэ анхны хэлэлцүүлгээс нь эцэслэн батлах үе шат руу нь хуулийг шилжүүлчих нь зүйтэй байна. Үүнийг манай гишүүд дэмжих хэрэгтэй гэж би ингэж хүсэж байна.

Н.Наранбаатар: Батжаргал гишүүний горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Одоо сайд нь ирэхээр хариулт өгнө. Сайд яасан бэ? Дэд сайд нь ядаж яадаг юм, хаачсан юм бэ? Сайд нь хаана яваа юм. Батбаяр гишүүн горимын санал. Батбаяр гишүүн.

Д.Батбаяр: Энэ өдрийн мэнд. Өнөөдрийн Байнгын хорооны хурал дээр хэлэлцэх асуудалд орсон байгаад байгаа юм. Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай асуудлыг эхлээд хэлэлцэж, одоо хэлэлцье гэсэн горимын санал гаргаж байна. Санал хурааж өгнө үү.

Н.Наранбаатар: Энэ асуудлыг түр хойшлуулаад, дараагийн асуудал гэж горимын санал гаргаж байна тийм ээ Батбаяр гишүүн. Горимын саналаар санал хураалт явуулъя, дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүй болгоё, санал хураалтад бэлтгээрэй гишүүд. Цуцлагдсан гэж гарч ирээд байна шүү, мөн үү? Тэгвэл одоо тэгээд шууд санал хураалт явуулж болох нь уу? Горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 62,5 хувиар дэмжигдлээ. Энэ асуудлыг түр орхиод, дараагийн асуудалдаа орчихъё.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын Их Хурлын гишүүн Золжаргал нарын 25 гишүүнээс 2026 оны 5 сарын 1-ний өдөр нийслэлийн 2024-өөс 2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн

хэрэгжилтийн талаар ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлтээ Монгол Улсын Их Хурлын даргад ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д УИХ хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор ерөнхий хяналтын сонсгол явуулна гэж, мөн хуулийн 29.2-т УИХ нь Улсын Их Хурлын 15-аас доошгүй гишүүн хүсэлт гаргасан тохиолдолд ерөнхий хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу заавал явуулна гэж заасны дагуу дээрх сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулсныг та бүхэнд тараасан.

Энэ асуудал 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэгдсэн бөгөөд өнөөдөр хэлэлцэгдэх Байнгын хорооны тогтоол Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох хугацаа өөрчлөгдөхөөр тогтоолын төсөл бэлтгэгдсэн байна. Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1.2 дахь заалт, 119.2 дахь хэсэг, 121 дүгээр зүйлийн 121.1, 121.13 дахь хэсэг, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Төсвийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Нийслэлийн 2024-өөс 2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдлын талаар Ерөнхий хяналтын сонсголыг 2026 оны 6 дугаар сарын 15, 16-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.Нийслэлийн 2024-өөс 2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдлын талаар Ерөнхий хяналтын сонсгол даргалагчаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргалыг сонгосугай.

3.Ерөнхий хяналтын сонсголын зарыг нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг ханган, холбогдох хууль журамд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт Өлзийсайханд даалгасугай. Төсвийн байнгын хорооны дарга Наранбаатар гэсэн ийм хуулийн тогтоолын төсөл байна. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүд нэрсээ өгье? Цогтбаатар, Золжаргал гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүн. Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Нийслэлийн төсөв, хөрөнгө оруулалтын төслүүдийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар ерөнхий хяналтын сонсгол гаргах саналыг 2026 оны 5 дугаар сарын 1-нд гаргаад, 25 гишүүн зураад ингээд өгсний дагуу өнөөдөр хэлэлцэж байна. Тэгэхээр одоогоос энэ чинь бараг 18 хоногийн өмнө буюу энэ асуудал маань нийслэлийн удирдлага хөдөлгөөнтэй холбоогүй бөгөөд 2 үндсэн шалтгааны улмаас гарч ирсэн.

1 дүгээрт нь нам намаас гишүүд асуудлуудыг тавьж байгаа. Ер нь энэ улсын төсвийн хөрөнгө оруулалт нийтдээ 8 их наяд төгрөг байгаад байдаг, тэрний тал нь нийслэл, орон нутаг байдаг. Гэтэл нийслэл дээр баталсан төслүүдийнх нь хөрөнгө оруулалт нь өөрөө 5 их наяд гараад явчихсан байдаг. Тэгээд хүссэн, хүсээгүй угаасаа төсөв дээр ийм тэнц бус disbalanced үүсчхэж байгаа. Тэгэхээр энийг ер нь цаашдаа яаж явах юм бэ гэдэг нэг том асуудал.

2 дахь нь болохоор томоохон төслүүдийн хууль тогтоомжид нийцтэй эсэх, санхүүгийн схем, тэгээд төсвийн хэрэгжилт дээр зөндөө их зөрчил гараад байна гээд олон нийтийн зүгээс, дээрээс нь Улсын Их Хурлын гишүүдээс, ингээд мэргэжлийн хүрээллээс маш их гомдол саналууд гарч байгаа. Тэгэхээр энэ асуудлыг нээлттэй хэлэлцээд, санал, дүгнэлт боловсруулах, ер нь цаашдаа ямар эрх зүйн орчиндоо зохицуулалт хийх шаардлагатай вэ гэдгийг тийм дэлгэрэнгүй, сайн нээлттэй хэлэлцэх шаардлагатай юм байна гэж миний бие бөгөөд их олон гишүүд аль, аль намын гишүүд ингэж үзсэн. Тэгээд энэ үүднээс санаачилсан хүний хувьд энэ үгийг хэлье.

Сонсголыг даргалах хүсэлтэй байгаа. Аль, аль намд нь харьяалагдахгүй хүний хувьд мэргэжлийн байдлаар нь тоон харьцуулалт болоод, хууль тогтоомжийн зүйл, заалтаар нь тэгээд мэргэжлийн байдлаар ажиллана гэж бодож байна.

Н.Наранбаатар: Үг хэллээ, Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Энэ тогтоолын төсөл гарахыг дэмжиж байгаа. 2016 оноос хойш нийслэлд Бат-Үүл даргаас хойш гэсэн үг шүү дээ Су.Батболд дарга, Ж.Батбаясгалан дарга, С.Амарсайхан дарга, Д.Сумъяабазар дарга, Х.Нямбаатар дарга гээд дандаа МАН-ын дарга нар нийслэл хотыг удирдсан. Тэгээд энэ нийслэл хот дээр энэ болж байгаа, болохгүй байгаа асуудлууд дээр буюу энэ тогтоолын төсөл дамаа 24 оноос 26 оны хооронд хийгдэж байгаа ажлуудыг буюу МАН эрх баригч намын төсөвт нь хяналт хийх сонсгол зохион байгуулъя гэж байгаа юм. Тэгэхээр хяналт хийх юм чинь энэ дээр 11 гишүүнтэй ажлын хэсэг байгуулагдах гэж байх шиг байгаа юм. 6 хүн нь МАН-аас байгаа юм. Хяналт хийх гэж байгаа юм. Тэгээд энэ дээрээ энэ МАН-аас байгаа гишүүдийнхээ тоог цөөлөөд, намгүй гишүүд байна, Үндэсний эвсэл байна, Иргэний Зориг ногоон нам байна, Ардчилсан нам /АН/ байна, ХҮН нам байна гээд эд нараас оруулаад 11 гишүүнээ бүрдүүлчихвэл яасан юм бэ гэсэн ийм горимын саналыг гаргаж байгаа юм. Тийм учраас хуралдаан даргалагч Байнгын хорооны дарга та энэ сонсгол зохион байгуулагч 11 гишүүнээс 6-аас дээш буюу олонхыг нь цөөнх эсвэл намгүй гишүүдээс бүрдүүлж өгнө үү гэдэг ийм хүсэлттэй горимын санал гаргаж байна.

Н.Наранбаатар: Дараагийн асуудал дээр энийг ярина. Санал хураалт явуулна, гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Гишүүд санал хураалтад бэлдээрэй, 9 хүн. Ганхуяг гишүүн ороогүй байна. Даваасүрэн, Түвшин, Тэмүүлэн. Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 62,5 хувиар дэмжигдлээ. Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх хэлэлцэж дууслаа.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Эргээд түр нээлттэй орхисон, одоо Ажлын хэсэг. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэгт Байнгын хороо сонсгол зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж болно гэж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9.7-д хуульд өөрөөр заагаагүй бол Байнгын хороо хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалтын болон энэ хуулийн 9.2.1, 9.2.2-т заасан асуудлаар тогтоол гаргана гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Золжаргал нарын 25 гишүүний гаргасан хүсэлтийн дагуу нийслэлийн 2024-өөс 2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдлын талаар Ерөнхий хяналтын сонсголын бэлтгэл хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулсныг танилцуулъя.

Ажлын хэсэгт орж ажиллах Улсын Их Хурлын гишүүдийн нэрсийг УИХ дахь намын бүлгүүдээс ирүүлсэн байгаа. Ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэгт Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Нийслэлийн 2024-өөс 2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдлын талаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэл хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч Д.Энхтүвшин, гишүүдэд Алтаншагай, Батболд, Баярмаа, Бум-Очир, Заяабал, Золжаргал, Лодойсамбуу, Сайнзориг, Хэрлэн, Цогтбаатар.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо Наранбаатарт даалгасугай. Төсвийн байнгын хорооны дарга Наранбаатар гэсэн ийм ажлын хэсэг байна. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу? Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Энэ 16 оноос хойш нийслэлд МАН дангаараа засаглаж өдий хүрсэн. Тэгээд түрүүчээсээ авлигын хэргүүд, тендерүүдийг өөрсдөө завшсан гээд нийслэлийн төлөөлөгч эсвэл нийслэлийн орлогч дарга нар нь холбогдоод явж байгаа. Тэгээд энэ 2024 оноос хойш эхэлсэн энэ нийслэлийн төсөв, санхүү энэ чинь яг бүр онцгой үед таарч байгаа. Нийслэл түүхэндээ хамгийн их буюу 4,1 их наяд төгрөгийн зарцуулалтыг хийсэн энэхүү зарцуулалт дээр нь ажлын хэсэг байгуулъя гэж байгаа. Тэгээд энэ ажлын хэсэгт багтаж байгаа 11 гишүүнээс 6 нь буюу олонх нь МАН байгаа юм. Тэгэхээр хуралдаан даргалагч Байнгын хорооны

дарга горимын санал байна. Ямар гэхээр энэ Байнгын хорооны 11 гишүүнээс олонхыг нь буюу 6-аас дээшхийг нь МАН-аас бусад ХҮН нам, Үндэсний эвсэл, Ардчилсан нам, Иргэний зориг ногоон нам, эсвэл нам бус гишүүдээс бүрдүүлж өгнө үү гэдэг нэг ийм горимын санал байгаа.

2-т нь энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах дээр Төсвийн байнгын хороо биш, Төсвийн зарлагын хяналтын дэд хороог хяналт тавихаар оруулж өгнө үү гэж. Ийм 2 санал хэлэх гэсэн юм.

Н.Наранбаатар: 2 горимын санал гаргасан. Эхнийх нь болохлоор зэрэг өнөө харьцаатай холбоотой асуудал. Энэ Их Хурлын тухай хуулиараа харьцааг нь өнөө сонгуулийн дүнгээр байгуулагдсан сонгогдсон нам, эвслийн бүлгийн харьцаагаараа сонгоно гээд энэ Дэгийн хуультай. Цогтбаатар гишүүний гаргасан горимын саналаар эхнийхээр нь санал хураалт явуулъя. Санал хураалт. Горимын санал гаргачихсан болохоор. Байнгын хороо, тийм Байнгын хороо, ажлын хэсэг тийм харьцаатай байх ёстой. Зөвлөх Гандулам зөвлөх уншаад танилцуулъя.

Б.Гандулам: Төсвийн байнгын хороо Гандулам. Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын Байнгын хорооноос байгуулагдаж байгаа ажлын хэсэг бол УИХ дахь олонх, цөөнхийн харьцааг харгалзаж байгуулагдана гэсэн хуулийн заалттай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10.1-д сонгуулийн дүнгээр УИХ-д 64 ба түүнээс дээш суудал авсан нам, эвслийг УИХ дахь олонх гэнэ гэсэн байгаа. Энэ хяналтын сонсголын ажлын хэсгээ байгуулахаар Байнгын хорооноос УИХ дахь МАН-ын бүлэг болон АН-ын бүлэгт албан бичиг хүргүүлсэн. Тэр албан бичгийн дагуу нэрсүүд ирсэн байгаа.

Н.Наранбаатар: Энэ дагуу ингээд, 1 дэхээ татаж авсан. 2 дахь санал нь, 2 дахь нь хуулийн биелэлтэд төсвийн. 2 дахь саналаар санал хураалт явуулъя. Санал хуралтад бэлтгээрэй, гишүүд анхааралтай. Цогтбаатар гишүүний горимын саналаар санал хураалт. 31,3 хувиар дэмжигдсэнгүй.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ чинь бэлдэх ёстой юу, шууд. Гишүүд санал хураалт. 56,3 хувиар дэмжигдлээ. Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

16.19 цаг

Сангийн сайд ирсэнтэй холбогдуулан түрүүний хойшлуулсан асуудлаа үргэлжлүүлэн хэлэлцье. Цогтбаатар гишүүн. Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Монгол Улсын 34 дэх Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарар удирдуулсан ЗГ-ын үед эхэлсэн ОТ-той холбоотой хэлэлцээр хийх ажлын хэсэг үргэлжилж яваад, сая тодорхой хэмжээний амжилт үзүүлээд Сангийн сайд маань хоцорч орж ирж байгаа юм байна. Тэгээд та хэдэд баяр хүргэе.

Энэ гадаадын зээл ашиглалттай холбоотой тусгайлсан хууль дээр асуух асуулт нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс энэ 2 төслийг тусад нь гаргаад, энэ газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС барих төсөл 2-ыг тусад нь гаргачихаар тооцооллынхоо хувьд жишээлэхэд энэ олон улсын үнэлгээний байгууллагууд буюу энэ Fitch ч юм уу, рейтинг тогтоодог байгууллагууд, эсвэл олон

улсын санхүүжүүлэгч байгууллагууд Монгол Улс яг хэдий хуулиа баталсан ч гэсэн олон улсынхаа тооцооллынхоо хувьд энэ чинь төсөв дотроо орж явна л гэдэг ийм агуулгыг илэрхийлээд байгаа юм. Тэгээд бид энэ Улсын Их Хурлын нэрийн өмнөөс асууж байгаа учраас УИХ-д зөвлөмж ирүүлж байгаа төсвийн тогтвортой байдлынхаа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөө зөвлөмжид итгээд байна гэх юм уу. Тэгэхээр яг энэ тооцоололтой холбоотой асуудлууд дээр нь зөв хариулт өгөхгүй, үгүй энэ зөв хариултыг нь нийгэмд өгөхгүй бол нэг эргэлзээ байна.

2 дугаарт энэ 16 оноос хойш МАН, Мэндсайхан сайд миний санаж байгаагаар 2 ч ЗГ-т нь орж ажилласан. Тэгээд энэхүү асуудлыг одоо яаралтайгаар оруулж ирэхгүйгээр жишээлэхэд энэ сая 3 сарын 15-наас эхэлсэн хаврын чуулганы үед зөв голдирлоор нь эсвэл энэ Энэтхэгийн ЗГ-тай харилцан тохиролцоо хийгээд, энэ Хятадын ЗГ-тай харилцан тохиролцоо хийгээд, энэхүү төслүүдийг зөв зарчмаар нь буюу эсвэл Хөгжлийн банкаар дамжуулаад заавал ингэж яаралтай горимоор өргөн барихгүйгээр 3 сар өнгөрч байхад шийдэж байхгүй яасан юм бэ гэсэн ийм 2 асуулт байна.

Н.Наранбаатар: Сангийн сайд хариулъя.

3.Мэндсайхан: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр юун дээр 2 төсөвтэй болоод төсвийн юугаар гараад явчихна, төсвийн бүртгэлээс гараад явчихна гэдэг ойлголт байхгүй. Гадаад зээл ерөөсөө гадаад зээлийнхээ хэсэгтээ энэ чинь бүртгэлтэй явж байгаа, Монгол Улсын ЗГ-ын авсан зээл учраас бүртгэлтэй явна. Нөгөө талдаа зарцуулалтыг нь бид энэ гүйцэтгэлээр нь санхүүжүүлээд явна шүү дээ. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн төсвийн гадуур бүртгэл явна гэсэн ойлголт байхгүй.

2 дугаарт хөгжлийн, энэ хийсэн зээлүүд маань хэрэгжээд ирчихсэн төслүүд маань Монгол Улсын ЗГ-тай хийсэн зээлийн хэлэлцээр. Ийм учраас энэ хөнгөлөлттэй зээлийн ангилалд ороод явж байгаа юм. Хөгжлийн банкаар хийвэл яах вэ цаад зээлдэгч нартайгаа таны хэлж байгаагаар дахиж ярилцаж болно. Гэхдээ дахиж ярилцлаа гэхэд энэ зээл шинээр хийх зээлийн хэлбэр буюу арилжааны зээл рүүгээ ороод, зээлийн хүү гэдэг асуудал шинээр яригдаж эхэлнэ. Нэг ёсондоо энэ хэрэгжээд эхэлж байгаа төслүүд маань бүгд шинээр эхэлнэ гэсэн үг. Эндээс үүдээд нөгөө төсөл, хөтөлбөр маань зогсох, төсөвт өртөг нэмэгдэх асуудал маань үүснэ.

Ер нь зүгээр яах вэ таны хэлж байгаа санааг би ойлгож байна. Цаашдаа бид манай улс чинь нөгөө нэг дундаас дээшээ орлоготой, хөгжиж байгаа орны ангилалд орчихоод байгаа учраас хөнгөлөлттэй болон нэн хөнгөлөлттэй зээл одоо манайд олгогдохгүй, харин арилжааны зээл олгогдох ийм нөхцөл рүү орж байгаа. Тэгэхээр энэ донор орнуудтайгаа, цаашдаа бид Хөгжлийн банкаар явж эрх зүйн зохицуулалтыг нь хийх шаардлагатай. Гэхдээ манай Хөгжлийн банк донор орнуудын тавиад байгаа буюу тэр бусад орны Эксим банкны шаардлагад нийцэхгүй байна. Ийм зовлон байна. Тэгэхээр одоо энэ 2 төслөө бид цаг хугацаанд нь яаралтай явуулахын тулд энэ хуулийн төслийг оруулж ирсэн юм гэдгийг танд хэлье.

Н.Наранбаатар: Тодруулах уу? Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Батжаргал гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Одоо дахиж, 10 хүн байна шүү дээ хүрэхээр байна шүү дээ. Цогтбаатар санал өгчхөөд л гарчихгүй юу. Санал хураалтад бэлдчихсэн үү бүгдээрээ? 10 хүн санал хураалтад. Гишүүд санал хураалтад. Орсон уу?

Батжаргал гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 62,5 хувиар горимын санал дэмжигдлээ. Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан танилцуулна. Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

16.26 цаг

Дөрөв.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудал. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Бат-Эрдэнийн Хулан Сангийн дэд сайд, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Батжаргалын Цогтнараран Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Баатарын Болд Татварын ерөнхий газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Мэндсайхан танилцуулна. Сая санал хураалтад Цогтбаатар гишүүнийг дэмжсэнээр авъя. Сангийн сайдын микрофоныг өгье.

3.Мэндсайхан: Төсвийн байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт татварын шинэчлэл хийхээр тусгагдсаны дагуу ЗГ-ын боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн Татварын хуулийн шинэчлэлт, өөрчлөлтийн төслүүдийг танилцуулж байна. Энэ хүрээнд Сангийн яам татвар, гаалийн байгууллага, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Улаанбаатар хотын худалдааны танхим болон УИХ-аар Тамгын газартай хамтран улс орон даяар давхардсан тоогоор 13 мянга гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, 176 мянга гаруй санал хүлээж авлаа. Иргэд, аж ахуйн нэгж /ААН/-үүдээс татварын ачааллыг бууруулах, хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэхэд татварыг энгийн ойлгомжтой, илүү уян хатан болгох зэрэг саналуудыг голчлон ирүүллээ.

Түүнчлэн Ойрх Дорнодод үүссэн геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн газрын тосны үнийн тогтворгүй байдлаас үүдэн инфляцын түвшин нэмэгдэж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өсөх нөхцөл бүрдээд байна. Энэ нь макро эдийн засгийн болон бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдал, иргэдийн бодит орлого, худалдан авах чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Иймд гадаад орчноос үүдэлтэй эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах, инфляцын гэнэтийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх,

эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, ААН-үүдийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих шаардлага тулгараад байна.

Сангийн яам дээрх уулзалт, хэлэлцүүлгээс гарсан саналуудыг судлан үзэхээс гадна ОУБ-аас өгч буй санал, зөвлөмжийг харгалзан үзэж, хуулиудын татварын хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсрууллаа. Энэ удаагийн татварын хуулиудын нэмэлт, өөрчлөлтөөр хариуцлагатай татвар төлөгчийг дэмждэг, урамшууллыг татварын тогтолцоог бүрдүүлэхээр зорьсон. Энэ удаагийн татварын хуулиудын нэмэлт, өөрчлөлтөөр иргэн, ААН-ийн татварын ачааллыг 2,2 орчим их наяд төгрөгөөр үе шаттай бууруулна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл татвар, гаалийн байгууллага хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих, эрсдэлд орохоос нь өмнө анхааруулах, зөрчлөө засах боломжийг олгодог болох, татварын өр барагдуулах үйл ажиллагааг уян хатан болгоход чиглэгдэнэ. Тухайлбал, 1.хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих, урамшуулах, татвар төлөгчийн эрсдэлд орохоос, татварын эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор гааль, татварын албанд татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшнийг тодорхойлон, татвар төлөгчид мэдэгдэж, татварын тайлан ноогдлоо татвар төлөгч өөрөө засах, зөрчлөө арилган татварын эрсдэлээс сэргийлэх боломжийг олгоно.

2.Татварын өр барагдуулах ажиллагаанд татвар төлөгчийн санхүүгийн чадамж, бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй хүндрэл эрсдэлийг харгалзан дансыг бүхэлд нь битүүмжлэх бус орлогын тодорхой хувийг суутгах, дансыг хэсэгчлэн битүүмжлэх замаар татварын өрийг төлөх боломж бүхий зохистой үе шаттай арга хэмжээ хэрэгжүүлнэ.

3.Татвар төлөгчийн алдаа зөрчлөө өөрөө арилгах боломжийг бүрдүүлэх зорилгоор татварын тайлан залруулах хугацааг 2 жил болгон нэмэгдүүлнэ.

4.Татвар төлөгчид их хэмжээний алданги тооцуулах, эрсдэлээс хамгаалах зорилгоор алдангийн дээд хэмжээг Иргэний хуульд заасан хэмжээтэй уялдуулан тогтооно. Түүнчлэн татварын актад гомдол гаргасан тохиолдолд алданги, торгууль нэхэмжлэхгүй. Маргаан эцэслэн шийдвэрлэсний дараа хураана.

5.Татварын алба хооронд татварын зорилгоор автоматаар харилцан мэдээлэл солилцох стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотой тухайн үүргийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхойлох, шаардлагатай мэдээллийг бүрдүүлж, уг мэдээллийг тогтоосон хугацаанд олон улсын жишигт нийцсэн хэлбэрээр бусад гишүүн оронд хүргүүлэх, нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг холбогдох байгууллага, эрх бүхий этгээдэд олгох зэрэг өөрчлөлт тусгалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Хуулийн төсөл батлагдсанаар татвар төлөгчийг алдаа гаргасны дараа хяналт шалгалт хийж, акт, торгууль тавих бус татварын тайланг задруулах хугацааг сунгаж, татварын алба эрсдэлээс урьдчилан сэргийлж, татвар хураалт, татварын хяналт шалгалтын үйл ажиллагааг илүү үр дүнтэй, чирэгдэл багатай, эрсдэлд суурилсан байдлаар хийж гүйцэтгэх нөхцөл бий болно.

Мөн Глобал форумын гишүүн орны хувьд автоматаар мэдээлэл харилцан солилцох стандарт хэрэгжүүлэх нэмэлт зохицуулалтуудыг тусгаснаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрийг бүрэн хэрэгжүүлэх боломж бүрдэж, татвараас зайлсхийх болон хууль бус санхүүгийн гүйлгээг бууруулах, дотоодын орлогыг хамгаалах, татварын бааз суурийг нэмэгдүүлэх, татварын ил тод байдлыг нэмэгдүүлэх эерэг үр дүн гарна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Н.Наранбаатар: Мэндсайхан сайд баярлалаа. Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна. Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: 63.2 дээр энэ нөгөө дансанд ирээдүйд орж ирэх мөнгөн хөрөнгөөс үл маргах журмаар гаргуулах татварын өрийн хэмжээ тухайн орлогынх нь 80 хувиас хэтрэхгүй байна гэж. Энэ дээр та хэд хийсэн судалгаа байгаа юу? Ер нь энэ татварын өрнөөс болж хаагдсан энэ ААН-үүдийн хувьд энэ гарч байгаа гүйлгээнүүд нь ялангуяа ААН-үүдийн хувьд бизнес тасралтгүй явуулахын тулд энэ цалинтай холбоотой зардлууд асар их үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахын тулд гардаг. Тэгэхээр энэ 20 хувийг гэхээр энэ яг бодит байдал дээр ямаршуу дүнтэй ийм зардлууд гардаг юм гэж бодож байна. 20 хувь гэхээр их бага сонсогдоод байна л даа. Энэ дээр тийм хийсэн судалгаа байгаа юу? Яагаад 20 хувь гэдэг тоо тавьсан бэ?

Н.Наранбаатар: Сангийн сайд хариулъя. Хэн хариулах вэ? 3 номерын микрофоныг нээе.

Б.Цогтнаран: Татварын ерөнхий газар Цогтнаран. Гишүүний асуултад хариулъя. Татварын өр хураах албадлагын арга хэмжээг Татварын ерөнхий хуулиар зохицуулсан. Өмнөх хуулийн зохицуулалтаар татвар төлөгчдөд удаа дараа мэдэгдэл хүргүүлээд, нийтлэг ажиллагаа хэрэгжүүлээд, төлөгдөөгүй тохиолдолд татварын өрийг барагдуулах зорилгоор арилжааны банк дахь дансыг битүүмжлэх ийм хуулийн зохицуулалттай. Өмнөх татварын реформын хүрээнд хийгдсэн бас нэг онцлог 20 оны хуулийн онцлог бол татварын давуу эрхийн зарчмыг ингэж хуульчилж өгсөн байсан.

Одоогийн өргөн барьж байгаа хуулиар данс битүүмжлэх ажиллагааг ирээдүйд орж ирэх орлогынх нь 20 хувийг нь татвар төлөгчдөө үлдээе гэдэг ийм байдлаар хуулийн төслийг оруулж ирж байгаа. Яг орж ирж байгаа орлогоос тодорхой хэмжээний үйл ажиллагаагаа тасалдалгүй явуулах зорилгоор энэ хувь хэмжээг тогтоож оруулж өгсөн. Яг ажилчдын цалинтай холбоотой, үйл ажиллагаа хэвийн явуулахтай холбоотой хувь хэмжээнүүд судалгаагаар 50 гаруй хувь нь, 50-аас нөгөө үйл ажиллагааныхаа чиглэлээс хамаараад ялгаатай байдаг юм байна лээ. Тэгээд олон улсад энэ татварын дансыг битүүмжлээд, татвар төлөгчдөө үлдээх энэ хувь хэмжээ нэг 10-аас 50 хувийн дотор ингээд хэлбэлзсэн байхаар хуулийн зохицуулалт хуулиуд ингэж үйлчилдэг юм байна лээ олон улсад.

Н.Наранбаатар: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Тэр 20 хувийн болохоор эдийн засгийн хувьд нэлээн харьцангуй тогтчихсон, жигдэрчихсэн, ашигт ажиллагааны түвшин ч гэсэн нэлээн боломжийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг улсууд. Ялангуяа Австрали зэрэг орнуудад иймэрхүү хувь хэрэглэдэг. Тэгэхээр яах вэ манай хувьд болохоор мэдээж татвар төлөх ёстой. Тэгэхдээ үйл ажиллагааг нь явуулж байгаад татвараа авбал илүү бодитой. Тэгэхээр данс нь хаагдсанаасаа болоод үйл ажиллагаа нь зогсох ийм эрсдэлүүд байдаг. Харин яах вэ энэ заалтаар энэ бага хэмжээгээр ч гэсэн энэ боломжийг нээж байгаа нь өөрөө тэр нөхцөл байдлуудаа дүгнэж үзээд ийм шийдвэр гаргаж байгаа болов уу гэж бодож байна. Гэхдээ бас хоёрын хооронд 20 хувь гэхээр сая таны жишээнээс салбаруудаас хамаараад 50 хүртэл хувь гэж байна. Тэгэхээр энэ нь хоёрын хооронд бага болоод, тэгээд үйл ажиллагааг явуулж тэр татвар хураамжийнхаа орлогыг нэмэгдүүлье гэхээсээ илүү бас л ялгаагүй.../минут дуусав/

Н.Наранбаатар: 3 номер.

Б.Цогтнарэн: Татварын ерөнхий газар Цогтнарэн. Энэ татварын данс, татварын өр хураах зорилгоор данс битүүмжлэх ажиллагааны талаар ярьж байгаа. Тухайн татварын ноогдлоо бол хуульд заасан хугацаандаа тухайн татвар төлөгч маань төлөх ийм хуулийн зохицуулалттай. Өөрөөр хэлбэл юу гэдэг юм тухайн төрлийн татварын төрлөөсөө хамаараад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улирлаар тайлагнана. Дараа сарын 20-ыхоо дотор тайлангаа гаргана. Мөн тэр хугацаандаа ингээд төлөх хугацааг нь тодорхой төрөл бүрээрээ ингээд ялгаатай хуульчлаад өгчихсөн.

Хуулийнхаа хугацаанд, хуульд заасан хугацаандаа тухайн тайлангаар үүсэж байгаа ноогдлоо төлж чадаагүй тохиолдолд татварын өр гэж үзэж байгаа. Өр үүссэнээс хойш тодорхой хугацаа өнгөрөөд ингээд албадлагын шат дараалсан арга хэмжээнүүд авагдаад байгаа юм. Тэгэхлээр энэ албадлага авч байгаа хувь хэмжээгээ 20 гэж байгаа хувь хэмжээгээ 50 хувь болгоод нэмэгдүүлбэл татварын.../минут дуусав/

Н.Наранбаатар: Нэмээд хариулчихъя, гүйцээгээд.

Б.Цогтнарэн: Мэдээж татвар төлөгчдийн нөгөө хууль даган мөрдөлтөд нөлөөлнө. Хугацаандаа татвараа төлдөг, тайлагнах, төлөх хугацаандаа татвараа төлөөд явдаг татвар төлөгчдөд мэдээж сөрөг үр дагавартай. Татварын хууль тогтоомж мөрдөлтийн түвшинд мэдээж нөлөөлнө. Сайн дураараа хууль даган мөрдөлтийн түвшинд нь тодорхой хэмжээгээр нөлөөлнө. Мөн татварын өрийн хэмжээ маань хуримтлагдах тийм эрсдэл бүхий нөхцөл байдал үүсэх юм. Тэгэхлээр нэгэнт л хуульд заасан хугацаагаа хэтрүүлээд, хуримтлагдсан өр төлбөр албадлагын арга хэмжээ ярьж байгаа хэмжээн дээр энэ 20 хувийг энэ дүнгээс илүү олон улсын жишигт байгаа, олон улсын практикт байгаа энэ дүнгээс илүү хэмжээгээр өсгөх нь өөрөө татвар хураах ажил дээр тодорхой хэмжээний эрсдэлүүдийг үүсгэнэ гэдэг ийм.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Алга байна. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг хойшлуулъя. 4, нэгтгээд явуулчихъя. Хуулийн төслийг, 4 хуулийн төслийг ЗГ багцаар нь барьсан учраас.

Тав.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудал ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсэг хэвээрээ. Хуулийн төслийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Мэндсайхан танилцуулна. Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт татварын шинэчлэл хийхээр тусгагдсаны дагуу ЗГ-аас боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийг танилцуулж байна. Энэ хүрээнд Сангийн яам татвар, гаалийн байгууллага, МҮХАҮТ, Улаанбаатар хотын худалдааны танхим болон Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран улс орон даяар давхардсан тоогоор 13 мянга гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, 176 мянга гаруй саналыг хүлээн авсан. Иргэд, ААН-үүдээс татварын ачааллыг бууруулах, хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэхэд татварыг энгийн ойлгомжтой, илүү уян хатан болгох зэрэг саналуудыг голчлон ирүүлсэн.

Түүнчлэн Ойрх Дорнодод үүссэн геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн газрын тосны үнийн тогтворгүй байдлаас үүдэн инфляцын түвшин нэмэгдэж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өсөх нөхцөл бүрдээд байна. Энэ нь макро эдийн засгийн болон бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдал, иргэдийн бодит орлого, худалдан авах чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Иймд гадаад орчноос үүдэлтэй эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах, инфляцын гэнэтийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, ААН-үүдийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих шаардлага тулгараад байна.

Сангийн яам дээрх уулзалт, хэлэлцүүлгээс гарсан саналуудыг судлан үзэхээс гадна, ОУБ-аас өгч буй санал, зөвлөмжийг харгалзан үзсэний үндсэнд татварын хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсрууллаа. Энэ удаагийн татварын хуулиудын нэмэлт, өөрчлөлтөөр хариуцлагатай татвар төлөгчийг дэмждэг, урамшуулдаг татварын тогтолцоог бүрдүүлэхээр зорьсон. Энэ удаагийн татварын хуулиудын нэмэлт, өөрчлөлтөөр иргэн, ААН-ийн татварын ачааллыг 2,2 их наяд төгрөгөөр үе шаттай бууруулахаар тооцож байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хэлэлцүүлгийн явцад ААН-үүдээс нийтлэг байдлаар ирүүлсэн саналууд буюу татвар ногдуулах орлогын босгыг нэгдүүлэх, шатлалыг өөрчлөх, жижиг, дунд ААН-үүдэд чиглэсэн хөнгөлөлт, чөлөөлөлтийг нэмэгдүүлэх, холбогдох зардлуудыг хасагдах зардалд тооцох, тайлан гаргах уян хатан болгох, бизнес эрхлэхэд татварын орчныг илүү хялбар, энгийн, ойлгомжтой болгоход чиглэнэ.

Тухайлбал, 1.ААНОАТ-ыг 25 хувиар тооцон ноогдуулж эхлэх. Татвар ноогдуулах орлогын босгын хэмжээ 6 тэрбум байсныг 10 тэрбум болгон 6-аас 10

тэрбум төгрөгийн татвар ноогдуулах орлогод 15 хувиар татвар ноогдуулан хөнгөлөлт үзүүлнэ.

2.Жижиг, дунд ААН-үүдийн татварын хөнгөлөлтийн хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилгоор төлсөн татварын 90 хувийг буцаан олголт, 1 хувийн татварын ачаалалтай байх босго дүнг 1,5 тэрбум төгрөгөөс 2,5 тэрбум төгрөг болгож өөрчлөх.

3.Мэдээлэл, технологийн үйлдвэрлэл дэмжиж, виртуал бүсэд үйл ажиллагаа явуулж буй ААНОАТ-ыг 100 хувь хөнгөлж, их хэмжээний өгөгдөл автоматаар боловсруулах зориулалттай тоног төхөөрөмж, график процессор бүхий сервер супер компьютер зэргийн элэгдэх хугацааг 3 жил байх зохицуулалтыг тусгах. ААНОАТ-ын тайлан тушаах, төсөвт төлөх хугацааг хойшлуулах зэрэг ААН-үүдээс ирүүлсэн саналд үндэслээд боловсруулсан өөрчлөлт тусгаж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын бизнесийн орчны өрсөлдөх чадвар сайжирч, бизнес эрхлэгчдийн татварын ачаалал буурна. Үүний үр дүнд эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийгмийн тогтвортой байдал бэхжүүлэх суурь нөхцөл бүрдэх ач холбогдолтой юм.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Н.Наранбаатар: Мэндсайхан гишүүнд баярлалаа. Мэндсайхан сайдад баярлалаа. Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Энэ 6-аас 10 тэрбум дээр 15 хувийн татвар ноогдуулах юм. Өөрөөр хэлбэл 25 хувь төлдөг 6-аас дээш 10 тэрбум хүртэлх ашигтай ААН-үүд 25 хувь төлдөг ААН-үүд 15 хувь болж байгаа юм байна. Энэ танилцуулга юун дээр болохоор 600-гаад ААН-үүдийн ачааллыг бууруулна гэхсэн байна. Тэгэхээр энд хэдэн төгрөгийн татварын хөнгөлөлт гэх юм уу, энэ өөрчлөлтөөр ААН-үүдэд энэ татварын ачаалал нь буурч байгаа вэ 1 дүгээрт? 2 дугаарт энэ жижиг нөгөө 1 хувийн хялбаршуулсан горимоор энэ бичил ААН-үүд дээр 1,5-ыг 2,5 болгож байгаа дээр энэ татварын ачаалал яаж буурч байгаа вэ гэсэн энэ 2 дүнг нийт дүнгээр нь багцаалж өгөөч?

2 дугаарт виртуал бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа технологийн чиглэлийн ААН-үүдийг татвараас хөнгөлнө гэж байна. Тэгэхээр энэ тогтоохдоо виртуал бүс гэдгийг нэг ойлгомжтой нэг стандарт тавьчихсан байсан тэгээд энийг нэг жоохон дэлгэрэнгүй тайлбарлаад өгч болох уу? Энэ ААН-үүд асуугаад байна лээ. Яг энийг яаж тогтоох юм гэдгийг нь. Хууль дээрээс харахаар болохоор яг нарийн харагдахгүй. Ийм. 2 асуулт байна.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? 6 номер.

Ч.Чимидсүрэн: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Татварын бодлогын газар Чимидсүрэн. 6 тэрбумаас дээших ашигтай ажиллаж байгаа компани өмнөх дата мэдээгээр авахаар зэрэг 620 ААН байгаа юм. Түүнээс 6-аас 10 тэрбумын ашигтайд нь 338 ААН байгаа юм. Нийт дүнгээрээ 162 тэрбумын

татварын ачаалал буурна гэсэн үг. 162. Тэгээд 1 хувийн ачаалалтай буюу өөрөөр хэлбэл 10 хувиар татвар төлөөд, 90 хувиа буцааж авч байгаа борлуулалтын орлогын босго бол 1,5 байсныг 2,5 тэрбум болгоход 4700 ААН нэмэгдэж энэ 2,5-тай болно гэсэн үг. Энэ дүнгээрээ тухайн ААН-үүдээс татварынх нь ачаалал 84 тэрбумаар, 84 тэрбумаар, ингээд нийт дүнгээрээ ААН дээр 250 тэрбумын татварын ачаалал буурч, тухайн ААН байгууллагууддаа үлдэж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, хөрөнгө оруулалтаа хийх боломж бүрдэнэ гэж үзэж байгаа. Виртуал бүс дээр нэмэлт юу өгчих үү.

Н.Наранбаатар: 9 номер нэмж хариулъя.

Н.Эрдэнэ: Сангийн яам Татварын бодлогын газар Эрдэнэ. Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийг байгуулах шийдвэрийг ЗГ-ын 98 дугаар тогтоолоор баталсан. Уг мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийг ажиллах журам, мөн виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журмыг тус тус баталсан байгаа. Уг журмын дагуу яг тухайн бүсдээ бүртгүүлсэн ААН-үүдэд уг хууль нь хэрэгжээд явна гэсэн үг. Одоогийн байдлаар 2026 оны яг 1 сараас виртуал бүсдээ компаниудаа бүртгэж эхэлсэн. Одоогийн байдлаар 85 гаруй ААН бүртгүүлсэн байгаа мэдээллийг Цахим яамнаас ирүүлсэн байгаа. Энэ хуульд болохоор одоогийн хуулиар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн эхний 5 жилийг татвараас хөнгөлж байсан бол хуулийн өөрчлөлтөөр уг хөнгөлөлтийг зөвхөн мэдээлэл технологийн үйл ажиллагаатай холбоотой гэдгээс гадна ер нь үйл ажиллагаатай холбоотой бүх орлогыг 100 хувь чөлөөлөлт.../минут дуусав/

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье? Алга байна. Гишүүд үг хэлж дууслаа.

Зургаа.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

ХХОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсэг хэвээрээ. Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Мэндсайхан танилцуулна.

3.Мэндсайхан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт татварын шинэчлэл хийхээр тусгасны дагуу ЗГ-аас боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийг танилцуулж байна. ХХОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг боловсронгуй болгох, албан татвар тайлагнах үйл ажиллагааг уян хатан болгоход чиглэгдэнэ.

Тухайлбал, 1.Иргэдийн татварын ачааллыг бууруулах зорилгоор хөдөлмөр эрхэлж буй иргэдийн сарын 792 мянган төгрөг хүртэлх орлогод ногдуулах татварыг 100 хувь хөнгөлж, буцаан олгох.

2.Бүх нийтээрээ шударга төлдөг татварын орчныг бүрдүүлэх зорилгоор үйл ажиллагааны орлогыг хялбаршуулсан горимоор тайлагнах босго дүнг 1 тэрбум төгрөгөөр тогтоож, борлуулалтын орлогын 1 хувиар татвар төлөх боломж олгох.

3.Татвар төлөгчийн тодорхой хугацаанд өмчилсөн орон сууцаа худалдан борлуулсан тохиолдолд үл хөдлөх борлуулсны албан татвараас чөлөөлөх.

4.Татвар төлөгчийн татвар тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор тайлан тушаах албан татварын төсөвт төлөх хугацааг хойшлуулах зэрэг өөрчлөлтүүд тусгагдаж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын иргэдийн татварын ачаалал буурч, бодит орлого нэмэгдэн, эдийн засгийн өсөлтийг иргэн, өрх бүрд хүргэх зэрэг чухал ач холбогдолтой байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, ХХОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Н.Наранбаатар: Мэндсайхан сайд баярлалаа. Танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Энэ ХХОАТ маань нөгөө НӨАТ-ын буцаалттай нэлээн уялдаж байгаа. Тэгэхээр яах вэ би зүгээр нийт нөгөө хөнгөлөлтийнх нь дүнг нь харьцуулж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний цалин хөлсийг 100 хувь хөнгөлөхөөр энэ хуулийн төсөлд тусгасан байна. Нөгөө талаасаа энэ татварын ачаалал ямар дүнгээр багасаж байгаа юм гэдгийг. НӨАТ-ын хөнгөлөлт болохоор энэ буцаалтын заалт болохоор 1,8 их наядын төсөв дээр ачаалал ирэхээр тооцоо гарч байсан. Тэгэхээр энэ заалттай хүн амын орлогын албан татвартай холбоотой энэ заалт дээр ямаршуу хэмжээний хөнгөлөлт, чөлөөлөлт олгохоор тооцсон бэ? Энийг харьцуулж харах гэсэн юм.

Н.Наранбаатар: 6 номер.

Ч.Чимидсүрэн: Гишүүний асуултад хариулъя. ХХОАТ-ын сарын цалингаас нь 792 мянгыг хөдөлмөр эрхэлж байгаа хүнээс 100 хувь хөнгөлөхөөр байгаа. Энэний жилийнх нь нийт дүн нь 840, энэ ХХОАТ 840 тэрбум. Энэ бол орон нутгийг буюу өөрөөр хэлбэл сум, дүүргийн төсвийг бүрдүүлдэг татвар байгаа. Тэгэхээр сум, дүүрэгтээ энэ хэмжээний орлого орохгүй гэхээр улсын төсвөөс татаас өгнө гэсэн үг дахиад 840 гэсэн үг. Тэгэхээр нийт дабл эффектээрээ буюу давхар эффектээрээ 1,7 их наяд, 1 их наяд 680 тэрбум байгаа. Энэ нь иргэдийн хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн татварын ачааллын 4 хувиар бууруулах тооцоо гарсан байгаа. Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын буцаалт 1,6-аас 1,8 их наядын төсвийн нөлөөтэй ийм тооцоолол гарсан байгаа.

Н.Наранбаатар: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Баярмаа нарын гишүүд яг энэтэй холбоотой төстэй хуулийн төсөл өргөн барьсан байгаа. Тэгээд 1 хувь болгоё гэсэн дүн дээрх ачаалалтай харьцуулж үзээд энэ нийт дүнгээр 1,7 их наядын хөнгөлөлт чөлөөлөлт өгч байна, биш төсөв дээр ачаалал ирж байна гэж ойлголоо. Хэрвээ тэр нэг, хүн амын орлогын

албан татварыг нэг хувь болгочихвол ямар хэмжээний ачаалал ирэх вэ энэ талаар мэдээлэл өгөөч?

Н.Наранбаатар: Сангийн сайд.

З.Мэндсайхан: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Энэ хүн амын орлогын албан татвар орон нутгийн татварыг бие даасан байдлыг хангахад хамгийн их ач холбогдол бүхий татвар байгаа. 1 хувь болгоход 2,7 их наядаар төсөв дээр ачаалал ирнэ, дам нөлөөгөөрөө 5,4 болно гэж бид үзэж байгаа. Яагаад гэхээр орон нутгийн төсөв бүрдэхгүй болчихвол энд нэг улсын төсвөөс бид татаас хэлбэрээр олгож таарна. Ингээд үзэхээр энэ боломжгүй юм гэж үзэж байгаа юм.

Ер нь зүгээр Энхтүвшин гишүүн түрүүнд та асуугаад байна. НӨАТ-ын татварын буцаалт дээр бид нэг ийм ойлголтыг авах ёстой юм билээ. Бид НӨАТ-ын буцаалтаа сүүлдээ юу гэж ойлгоод байна вэ гэхээр өмнө нөгөө нэг ЗГ оруулж ирэхдээ иргэдийнхээ 500 хүртэлх худалдан авалт дээр гээд үе шаттай бууруулах юу чинь явж, явж байгаад худалдааны татварын буцаан олголт биш, халамжийн бодлого шиг юм тайлбарлагдаад яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид тэрийгээ салгахгүй бол болохгүй юм байна лээ шүү гэдгийг танд.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгье? Алга байна.

Долоо.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнууд хэвээрээ. Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Мэндсайхан танилцуулна.

З.Мэндсайхан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт татварын шинэчлэл тусгахаар тусгагдсаны, хийхээр тусгагдсаны дагуу ЗГ-аас боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийг танилцуулж байна. Монгол Улс анх 1998 оноос нэмэгдсэн өртгийн албан татварыг нэвтрүүлж, улмаар Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг 2007, 2015 онд шинэчлэн найруулснаас хойш 10 жил өнгөрсөн байна.

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хүндрэлтэй нөхцөл байдлаас үүдэлтэйгээр төгрөгийн ханш суларч, инфляц, хүүгийн түвшин нэмэгдсэн тул хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ААН-үүдийн мөнгө, мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг дэмжих тухай асуудал нэн чухал холбогдолтой болж байна. Иймд иргэн, ААН-үүдэд үүсэж буй хүндрэлийг шийдвэрлэх шаардлага байна.

Монгол Улсад 2024 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн 58 орчим хувь нь мөнгөн хөрөнгийн дутагдалтай, 29 хувь буюу 30 мянган ААН нь алдагдалтай ажилласан, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн төлбөрийн чадвар буурах, санхүүгийн дарамтад орох, улмаар бизнесийн тогтвортой байдлаа хангахад хадгалахад хүндрэл үүсгэж байгааг харуулж байна. Иймээс дээрх нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, холбогдох арга хэмжээг авах шаардлага тулгарч байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон тус хуулийн төсөлтэй хамт боловсруулсан хуулийн төсөл нь бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, орлогын тэгш бус байдлыг бууруулахад чиглэнэ. Үүнд, 1.Бичил бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж олгох зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татвар суутгагчийн суутган төлөгчийн босгыг 400 сая төгрөг болгон нэмэгдүүлэх. 2.Татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшин, үйл ажиллагааны цар хүрээг харгалзан дотоод болон импортын нэмэгдсэн өртгийн албан татварын төлбөрийг 2 хүртэлх сарын хугацаагаар хойшлуулах боломжийг бүрдүүлж, ААН-ийн мөнгөн урсгал уян хатан байдлыг дэмжих. 3.Бусад улс орнуудын туршлагад үндэслэн шаталсан татварын тогтолцооны зарчимтай уялдуулан импортлосон суудлын автомашины гаалийн тодорхой үнийн дүнгээс нэмэгдэл хувиар тооцож татвар ногдуулах зохицуулалтыг тус тус тусгана.

Хуулийн төсөл батлагдсанаар бизнес эрхлэгчдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгө ачааллыг бууруулах, бизнес идэвхжих, тэлэх бололцоог хангах, үйл ажиллагаа өргөжүүлэх боломжийг нэмэгдүүлж, орлогын тэгш бус байдлыг бууруулах зэрэг ач холбогдолтой болно. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Н.Наранбаатар: Мэндсайхан сайдад баярлалаа. Танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Алга. Энхтүвшин гишүүн, Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Энэ татварын хуулийн 4.5.2-т биш ээ, 4.2 дээр нэг ийм ерөнхий хууль дээр татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулна гэсэн ийм нэг заалт байгаад байдаг. Тэгэхээр яах вэ саяын энэ орж ирж байгаа татварын хуулиуд маань хувь хэмжээ хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой асуудлууд байгаа учир энэ хуулийн заалттай яаж уялдаж байгаа вэ Татварын ерөнхий хуулийн 4.2 дугаар энэ заалт энийг нэг тайлбарлаж өгөөч?

2 дугаарт нь ААН-үүдийн хувьд ерөнхийдөө түрүүн Хүн амын орлогын албан татварын хуулийн төсөл бас танилцуулахдаа хэлж байсан. Нийтээрээ татвар төлдөг болъё гэдэг. Тэгэхээр НӨАТ-ын босгыг ингээд дээшээ болгочихоор энэ ААН-үүдийн, татвар төлдөг ААН-үүдийн хүсээд байгаа энэ юмныхаа эсрэг, тэгээд дээр нь тодорхой хэмжээнд энэ бизнесийн үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлэх. Нөгөө талаасаа жижиг, дунд ААН-үүдийн хувьд ч гэсэн НӨАТ төлөгч биш болохоор эдийн засгийн харилцаанд татвар төлөгч нартай харилцаанд ороход хүндрэлтэй асуудлууд үүсэхээр иймэрхүү дүр зургууд байгаад байна л даа. Тэгэхээр яах вэ миний асуух гээд байгаа энэ НӨАТ-тай холбоотой энэ босго өндөрсгөсөнтэй

холбоотойгоор энэ танхимаас ч юм уу, ААН, том татвар төлөгч ААН-үүдээс ямаршуу санал өгсөн юм бэ, энийг ер нь дэмжиж байгаа юм уу? Энэ талаар ямар нэгэн санал авсан, өгсөн юм байгаа юу гэдэг асуулт байна?

Н.Наранбаатар: 6 номер.

Ч.Чимидсүрэн: Гишүүний асуултад хариулъя. Хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд 27 оны 1 сарын 1-нээс төсвийн нөлөөтэй заалтууд нь хэрэгжинэ. Одоо данс битүүмжлэх гэдэг юм уу, эсвэл төсвийн нөлөөгүй заалтууд нь зарим нь шууд хэрэгжихээр байгаа гэж эхний асуултад товч хариулъя.

НӨАТ-ын босготой холбоотой асуудал байгаа. НӨАТ-ын босгыг бид 50 саяыг 400 сая болгож нэмэгдүүлж байгаа. Гэхдээ сайн дураараа НӨАТ суутган төлөгч болох босго хэвээрээ буюу 10 сая төгрөг хэвээрээ байгаа. Тэгэхээр 400 сая хүртэлхэд байх жижиг бичил ААН-д илүү энгийн хялбар байх, өөрөөр хэлбэл НӨАТ-ын тайланг гаргаж, сар болгон тайлан гаргаж, түүнтэй холбоотой зардал, захиргааны зардлуудыг нь хэмнэх зорилгоор хийгдсэн байгаа. Зүгээр ер нь саналууд дээр их ойролцоо гарсан. Ер нь босгогүй болгож нэвтрүүлж гэдгүүд ч бий, бүгдээрээ энэ тэгш шударгаараа төлдөг болъё гэсэн зохицуулалтууд буюу саналуудад 52 хувь нийт, 21 хувь ирж байсан. Босгыг нь 400 болгоё гэсэн энэ хувилбар ч гэсэн ерөөсөө нэлээн ойролцоо очиж санал дээр ирж байсан байгаа.

Н.Наранбаатар: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Энэ 4.2-ыг харахаар хуулийн төсөлтэй хамт боловсруулна гээд. Өөрөөр хэлбэл тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулна гэхээр төсөв дагуулж л энэ татварын хөнгөлөлт чөлөөлөлт, татварын хувь хэмжээ, суурь бууруулахтай холбоотой энэ асуудлуудыг оруулж ирэх юм шиг ингэж уншигдаад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл тэртээ тэргүй тухайн төсвийн жилдээ мөрдөж чадахгүй учраас дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлэх учраас заавал ингэж тусад нь оруулж ирэх. Тэгэхээр оруулж ирэхээр энэ 4.2-той зөрчилдөөд байгаа юм шиг л уншигдаад байгаа юм. Тэгэхээр энийг нэг сайн тайлбарлаад өгчихвөл. Би уншихдаа заавал төсөв дагуулж л энэ татварын хөнгөлөлт чөлөөлөлт, хувь хэмжээтэй холбоотой төслүүд орж ирэх ёстой юм байна гэж уншаад байгаа байхгүй юу. Энэ дээр дахиад нэг тодруулаад өгөөч.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? 6.

Ч.Чимидсүрэн: Татварын хуулийн хэлэлцүүлгийг тусад нь УИХ-аар хэлэлцүүлэх нь зохистой гэж үзсэн. Бидний хувьд ч гэсэн ингээд 4 хууль дээрээ нэмэлт, өөрчлөлтүүд аваад явж байгаа. Тэгээд хэрэгжих хугацааг нь бид тухайн саяын таны хэлсэн заалтад нийцүүлээд тухайн төсвийн жилийн дундуур хэрэгжихээргүй байхаар нөлөөллийг нь тооцож ингээд оруулаад яваад байгаа юм.

Н.Наранбаатар: Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.8 дээр нөгөө хэмжээг нь тогтоож өгсөн байгаа 50-аас 400 сая болгож өөрчлөөд. Тэгээд энэ дээр хувь хүн, хуулийн этгээд ялгаатай явах бодлого баримталж болохгүй байсан уу гэдэг дээр нэг? Жишээлэхэд иргэд юу гэдэг юм автомашин борлуулж байгаа иргэн ч юм уу, эсвэл Таванбогд энэ

нөгөө тоёота борлуулаад байгаа компаниудыг машин борлуулж байгаа ченжүүдтэй бид ижилхэн түвшинд авч үзэх чинь нэг ялгаатай татварын бодлого байвал зүгээр биш үү гэдгийг нэг асуух гэсэн юм?

2 дугаарт нь тэр ХХОАТ дээр үл хөдлөх хөрөнгө борлуулсны 2 хувийн татварын асуудал яригдаад яваад байгаа. Тэгээд энэтэй холбоотойгоор хот эсвэл аймгууд, тэгээд хот дотроо энэ төвийн дүүрэг гэдэг юм уу, алслагдсан дүүрэг гэдэг юм уу ялгаатай байдлаар тогтоож өгөхгүй бол бас нэг ялгаатай байдлаар тогтоогоод өгчихвөл уг нь нэг ийм зөв зохицуулалтад орж явах гээд байна гэж. Тэгээд энэчээнээсээ дахиад нөгөө анхны байр, анхны үл хөдлөх хөрөнгөө борлуулсан бол, тэгээд юу гэдэг юм энэ хот гэдэг юм уу, улс өөрөө бодлогоороо орон сууцны бодлого хэрэгжүүлж явах гэж байгаа бол нэг өрөө байраа яг зараад, 2 өрөө байр луу орж байгаа бол энэчээ яг татвар тооцоод явах уу? Яг зарчмаараа байраа зараад, дахиад байраа томруулж авч байгаа хэсэг дээр нь бид дахиад, эсвэл яг анхныхаа байрыг авч байгаа хүмүүс дээр бид ямар татварын хөнгөлөлт, дэмжсэн бодлого байх вэ гэсэн иймэрхүү асуултууд дээр хариулт өгөөч?

Н.Наранбаатар: 6 хариулъя.

Ч.Чимидсүрэн: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Иргэн, ААНБ дээр НӨАТ төлөгчийн босгыг ялгаатай тогтоож болоогүй юм уу гэдэг асуудал яригдлаа. Тэгэхээр энэ олон улсын практик дээрээ татвар төлөгч гэдэг утгаараа явж байгаа. Тэгээд НӨАТ-ын суутган төлөгч гэдэг үүргийг биелүүлж байгаа учраас энэнд иргэн, ААН-үүд дээр ялгах нь тийм зөрөөтэй асуудлыг үүсгэх боломжгүй гэсэн үг. Тэгэхээр ерөнхийдөө нийтлэг хэрэглэгддэг энэ олон улсын практик, манай дээр өмнө батлагдсанаас хойш хэрэгжиж байгаа энэ чиглэлээр явж байгаа.

Орон сууцны, иргэний орон сууцны борлуулалтын 2 хувийг чөлөөлөхөөр хуулийн төсөлд орж ирсэн. Энэ бол тодорхой иргэдийн санал гаргаад, 100 мянгаас дээш санал авсан асуудал. Мөн Улсын Их Хурлын зарим гишүүд үүн дээр хуулийн төсөл санаачлаад явж байгаа. Эдгээр саналуудтай уялдуулаад, ЗГ энэ асуудлыг хөндөх нь зүйтэй юм байна гэж авч үзээд, хуулийн төсөлдөө оруулж ирсэн. Оруулж ирээд томъёолохдоо иргэн өөрийн өмчилсэн орон сууцдаа 5-аас дээш жил амьдарсан бол 2 хувийн татварыг нь чөлөөлье гэдэг ийм заалтаар орсон. Энэ дээр анх удаа, нэг удаа гэсэн тийм хязгаарлалтууд ороогүй. 5 жил болоод борлуулчхаад, дахиад дараагийн байр дээрээ 5 жил тэр байгаад борлуулбал мөн л дахин 2 дахь удаагаа эдэлж болох зохицуулалт нь хуулиараа нээлттэй байгаа гэсэн үг.

Н.Наранбаатар: Цогтбаатар гишүүн тодруулъя.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Олон улсын практик гэхээр чинь би асуумаар санагдчихлаа. Жишээлэхэд бидний төсвийн бодлого олон улсын практик гээд ингээд дагаад яваад байх гэхээр манай энэ Монгол Улс чинь өөрөө аягүй онцлогтой орон. Нэг ийм 2 том хөршийн дунд, далайд гарцгүй, уул уурхайн бүтээгдэхүүний экспортоор дийлэнх орлогоо олж байгаа. Тэгээд бид юу гэдэг юм олон улсын практик гээд юу гэдэг юм тэр хөгжчихсэн орнуудынхтай ч юм уу, эсвэл өөр орлого олж байгаа орнуудтай харьцуулах гээд байх бидэнд шаардлага байхгүй. Бидэнд яг юу, ямар схем, ямар загвар тохирох вэ л гэдгээ бид олж харахгүй юм бол, эсвэл яг энэ хөгжиж байгаа орнууд дотор яг Монгол шиг далайд гарцгүй, ийм том хөршүүдийн дунд түгжигдчихсэн байгаа ийм орнууд гэж та нарт тэгж олон олдлоод байгаа юм уу? Яг заавал олон улсынх гэж ингэж хязгаарлаад байхаар чинь бид жишээлэхэд зүгээр

энэ бол жишээ. Энэ машин зарж байгаа иргэн нэг хүнээс нэг хуучин машиныг 10 саяар авдаг ч юм уу, түүнийгээ 11 сая 500.../минут дуусав/

Н.Наранбаатар: 1 минут.

Да.Цогтбаатар: Машины ченж чинь 1 сая, 1 сая 500 мянган төгрөгийн ашиг гэх юм уу хараад зарж байхад яг энэ дилер компаниуд чинь тэрнээс илүү хэмжээний ашиг харж байгаа, илүү хэмжээний орлого олж байгаа байх. Тэгэхээр миний хувьд аль болох ЗГ чинь өөрөө иргэддээ илүү боломжийг олгоё гээд байгаа энэ үүд хаалгаа нээхгүй байна шүү дээ гэдэг талаас нь л хараад байна. Олон улс гэж ярьсан учраас би асууж байгаа шүү.

Н.Наранбаатар: 6 номер хариулъя.

Ч.Чимидсүрэн: Тэгэхээр бидний хувьд энэ хуулийн хэлэлцүүлэг хийж байхад олон улсын байгууллагуудаас тодорхой тийм сайн, бусад улс орны сайн туршлага, онол арга зүйн асуудлууд дээр зөвлөгөө авч хамтарч ажилладаг. Тэгээд ер нь энэ НӨАТ-ын тогтолцоо, НӨАТ-ын систем дээр хэрэглэж болох нэлээдгүй л тийм арга механизмуудыг манай улс хэрэглээд явж байгаа. Тохирох, тохирох үед нь хэрэглээд явж байгаа. НӨАТ энэ систем дээр босготой байх асуудал дээр нийт 175 улс орноос 145 дээр нь босгыг хэрэглээд явж байна. Хөнгөлөлт чөлөөлөлтийн асуудлуудыг нэлээдгүй хэрэглээд явж байна. НӨАТ-ын урамшууллын буцаалтын механизмыг ашиглаж байна, сугалааны асуудлыг хэрэглэж байна гэх мэтчилэн ингээд тодорхой цаг үеүүддээ хуульдаа тусгаад энэ механизмуудыг ашиглаад явж байгаа.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. 7 гишүүн л байгаад байна, би өөрөө. Цогтбаатар гишүүн, орчхож. Даваасүрэн гишүүн, Ганхуяг гишүүн. Санал хураалтад бэлтгээрэй. Санал хураалт явна.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 62,5 хувиар дэмжигдлээ. Хууль тус бүр дээр нь хураах юм. Хуулийн төслийн талаарх хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Гомбын Ганбаатар танилцуулна. Татварын ерөнхий хуулийг танилцуулна.

Дараагийн санал хураалт. Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Түүрүүн бэлдчихсэн, одоо шууд. 68,8 хувиар дэмжигдлээ. Хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайхан танилцуулна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар, саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 68,8 хувиар дэмжигдлээ. Хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх

Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна.

Дараа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 68,8 хувиар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 68,8 хувиар дэмжигдлээ. Хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан танилцуулна. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

17.11 цаг

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА